



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/249

Есөнбулаг сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр худалдан авсан ГААХААГ/20260202038 дугаар Баян-Уул сумд Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд угаалга, ариутгал халдваргүйтэлийн тусгай зориулалтын ДУК машин нийлүүлэх ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ж.Очир

(Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Р.Цэнд-Аюуш

(Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)

Гишүүд

Д.Хандсүрэн

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын нярав)

Б.Золзаяа

(Орон нутгийн өмчийн газрын Өмчийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Б.Пүрэвжав

(Хүнс, хөдөө аж ахуйн газрын Захиргаа удирдлагын хэлтсийн дарга)

2.Тус ажлыг гэрээнд тусгагдсаны дагуу холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, гэрээний дагуу холбогдох газруудад хүлээлгэн өгч үр дүнг танилцуулахыг ажлын хэсэг (Ж.Очир)-т үүрэг болгосугай.

3.Орон нутгийн өмчид бий болсон хөрөнгийг бүртгэж, ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)-т, цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтыг хариуцаж ажиллахыг холбогдох газруудад даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ЧИНБАТ



D:zahiramjZax ZD 2026

8200080424